

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2025 оны
12 дугаар сарын 01-ний өдрийн _____ дугаар
албан бичгийн 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ХЭРЭГЖИЛТ


2025 оны 11 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

№	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	НХТЖУЧ-4.1.1	Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг эхлүүлнэ.	2021-2024	НЗДТГ НӨХГ	-	Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн сан байхгүй.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	-	-	2021 онд: "Өмчийн бүртгэлийн нэгдсэн систем"-ийн ажлын даалгаврын тоймыг боловсруулан системийн хөгжүүлэлт хийх, үнийн санал авах тухай 2021.08.27-ны өдрийн 3/1071-3/1075 тоот албан бичгийг "Ай Си Ти групп", "Интерактив", "Ухаалаг шийдэл", "Ай Ти Зон", "Новелсофт" компаниудад хүргүүлэн, "Ай Си Ти групп", "Интерактив", "Ухаалаг шийдэл" ХХК-иас 286.0-1,000.0 сая төгрөгийн үний санал ирүүлсэн. Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд 2022-2023 онд дамжин хэрэгжих 1,000.0 сая төгрөгийг суулгах санал дэмжигдээгүй байна. 2022 онд: ТӨБЗГ-ын даргын 2022 оны А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн программ хангамжийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэг"-т ажиллан, бодлогын даалгаврын төсөлд хуулийн этгээдийн мэдээлэл, өмчийн бүртгэл, хөрөнгийн хөдөлгөөн, өмч хувьчлал, төрийн өмчийн удирдлага зохицуулалттай холбоотой программ хангамжийн системд тусгах саналыг өгсөн. Нийслэлийн өмчийн мэдээллийн санг Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Хөрөнгийн удирдлагыг сайжруулснаар тогтвортой байдлыг дээшлүүлэх нь" төсөлтэй уялдуулан хэрэгжүүлэх танилцуулга, саналыг өгсөн. 2023 онд: Нийслэл биеэ даасан мэдээллийн нэгдсэн сантай болох зорилгоор НЗД-ын 2023 оны А/1138 дугаар захирамжаар "Цахим Улаанбаатар" төслийн 110 сая төгрөгийн санхүүжилтийн эрх шилжүүлэх ажил батлагдан НИТХ-ын 15-р тогтоолоор төсөвт өөрчлөлт орон төндөр хүчингүй болсон. 2024 онд: Гүйцэтгэгч "Ухаалаг шийдэл компани" ХК нь "Нийслэлийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын систем"-ийг 4 үед шаттай боловсруулсан. Үүнд: 1: Өгөөдлийн сэнгийн загвар, ERD зураг гарган, сэнгийн өгөөдлүүдийн зураг, хүснэгтийг гаргасан. Системийн топологи зургийг хөгжүүлэн Application server, Database server-т байршиж ажиллан, мэдээллийг татах, шлэх, дундын сан бий болгох системүүдийн судалгаа, системийн хөгжүүлэлтэд дагаж мөрдөх дүрэм журмуудыг судалсан. 2: Техникийн даалгаварт тусгагдсан тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. 3: Төслийн менежментийн ажлууд бүрэн хийгдсэн. 4: Системийн хөгжүүлэлтийн явцын бүх модулууд хийгдсэн. НЗДТГ-ын дарга Д.Амгалан, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, НӨХГ-ын хэлтсийн дарга нар 2025.05.08-ны өдөр ТӨБЗГ-ын дарга Б.Цэнгэл, Бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга Б.Нарангэрэл нартай уулзалтаар "Нийслэлийн өмчийн удирдлагын нэгдсэн систем"-ийг зогсоохоор шийдвэрлэсэн. Тус программыг дотоод үйл ажиллагаандаа ашиглах талаар судалж байна.	Үр дүн гарсан
2	НХТЖУЧ-4.1.1	Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн тоог бууруулна.	2021-2024	НӨХГ	-	5	Өөрчлөн байгуулсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо	18	-	-	2021 онд: НИТХ-ын 2021 оны 191 дүгээр тогтоолоор "Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ-ын татан буулгахаар шийдвэрлэсэн. 2022 онд: НИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ын татан буулгасан. 2023 онд: Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/76 дугаар захирамжаар нийслэлээс санхүүждэг үйлдвэрлэл, технологийн паркуудын хэлбэрийг өөрчлөн, компанийн дүрмийг шинэчлэн батлах санал, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт "Багахангай үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ, "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ, "Эмээлт үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ, "Налайхын барилгын материалын үйлдвэр, технологийн парк" ОНӨТҮГ-ын танилцуулга, дүрмийн төсөл, саналыг хүргэсэн. НИТХ-ын 2023 оны 67 дугаар тогтоолоор "Эмээлт үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-г хаалттай ХК болгон өөрчлөн байгуулж, дүрмийг баталсан. 2024 онд: НИТХ-ын 2024 оны 36 дугаар тогтоолоор "Багахангай үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ыг, 37 дугаар тогтоолоор "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ыг, 38 дугаар тогтоолоор "Налайх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ыг тус тус хаалттай ХК болгон өөрчлөн байгуулж, дүрмийг баталсан. НИТХ-ын 2024 оны 41 дүгээр тогтоолоор "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийг нийслэлийн өмчид 100 хувь шилжүүлэн авсан. НИТХ-ын 2024 оны 61 дүгээр тогтоолоор "Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт" ХХК-ыг, 87 дугаар тогтоолоор "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ыг, 122 дугаар тогтоолоор "Улаанбаатар зүүн Азийн наадам зохион байгуулах хороо" ХК, 123 дугаар тогтоолоор "Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ-ыг татан буулгасан. НИТХ-ын 2024 оны 28 дугаар тогтоолоор "Зорчигч тээвэр 1", "Зорчигч тээвэр 2", "Зорчигч тээвэр 3", "Зорчигч тээвэр 4", "Зорчигч тээвэр 5" ОНӨААТҮГ-ыг байгуулж, "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ, "Зорчигч тээвэр 3" ОНӨААТҮГ-ыг татан буулгасан.	Үр дүн гарсан

3	НХТЖУЧ-4.1.1	Нийслэлийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.	2021-2025	НӨХГ	-	2,075.4	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын дүн, сая.төг	9,665.8	-	-	НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам", "Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам" -ын дагуу нийслэлийн өмчийн ирүүдэлтэй байр талбайг иргэд, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээгээр эзэмшүүлэн давхардсан тоогоор нийт 1316 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажигласан. 2021-2025 оны зорилтот түвшингээр нийслэлийн төсөвт нийт 11,937.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025.11.28-ны өдрийн байдлаар 9,557.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнд: - 2021 онд 2,478.0 сая төгрөг, - 2022 онд 1,967.6 сая төгрөг, - 2023 онд 1,973.9 сая төгрөг, - 2024 онд 1,466.6 сая төгрөг, - 2025.12.01 өдрөөр 1,779.7 сая төгрөг.	Үр дүн гарсан
4	ТЖУЧ-4	Нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоож, хотын хөгжлийг дэмжих, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгоно.	2021-2022	НӨХГ	зэлийн	-	Зах зээлийн бодит үнэлгээ тогтоох барилга байгууламжийн дүн, сая төг	24	398	323.5	Зах зээлийн бодит үнэлгээгээр үнэлэх хийх нийслэлийн өмчийн томоохон барилга байгууламжийн судалгаа гарган, бэлтгэл ажлыг ханган, үнэлгээний ажлын зардлыг нийслэлийн 2022 оны төсөвт тусган батлуулан 2 үнэлгээний комисс байгуулан дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.НӨХТ-ын даргын 2021 оны А/581 дүгээр тушаалаар байгуулсан Үнэлгээний комисс нь Нийслэлийн өмчөөс 2022 онд хувьчлагдах эд хөрөнгийг үнэлэх зорилгоор хөрөнгийн үнэлгээ хийх 68.0 сая төгрөгийн бүхий зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Тендерт шалгарсан оролцогч "Мөнх Оргил Трөйд" ХХК-тай НӨАУГ/202201001 тоот зөвлөх үйлчилгээний (12.5 сая төгрөг) гэрээ байгуулан, нийслэлийн өмчийн 14 барилгад үнэлгээ хийлгэсэн. Үүнд: - Хар үнэгний аж ахуйн хөрөнгө - Мал эмнэлэгийн лабораторын хөрөнгө - СБД-ийн Тамгын газрын өргөтгөлийн хөрөнгө - СБД-ийн Нэгдсэн эмнэлгийн хөрөнгө - 50 дугаар дэлгүүрийн өргөтгөлийн хөрөнгө - Монгол шуудангийн барилга 36-р салбар - Монгол шуудангийн барилга 44-р салбар - Монгол шуудангийн барилга 26-р салбар - Монгол шуудангийн барилга 46-р салбар - Халуун усны барилга ХУД-ын 16 хороо - Халуун усны барилга СБД-ын 15 хороо - Халуун усны барилга СБД-ын 16 хороо - Халуун усны барилга СБД-ын 4 хороо - Халуун усны барилга СХД-ын 25 хороо 2.НӨХГ-ын даргын 2022 оны А/218 дугаар тушаалаар байгуулсан Үнэлгээний комисс нь Нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ (10 барилга, байгууламж) хийх 330.0 сая төгрөгийн өртөг бүхий зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Тендерт шалгарсан оролцогч "Прайс вотор хаус күүперс эдвайзори" ХХК-тай НХААГ/202204431 тоот зөвлөх үйлчилгээний (281.1 сая төгрөг) гэрээ байгуулан, нийслэлийн өмчийн 10 барилгад үнэлгээ хийлгэсэн. Үүнд: - Гэрлэх ёслолын ордны барилга - Хүүхдийн ордны барилга - Соёлын төв өргөөний барилга - Нийслэлийн Төр захиргааны 2 дугаар байр, 1 дүгээр хэсэг - Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр - Нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар байр - Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга - ХУД-ийн ЗДТГ-ын /шүүхийн/ барилга - ХУД-ийн ЗДТГ-ын /татварын/ барилга -ХУД-ийн Соёлын ордны барилга	Үр дүн гарсан
Хэрэгжилтийн дундаж хувь												

ДАГ



Б.ОЮУМАА

ХЯНАСАН: ЗУХ-ИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т. ОЮУНТУУЛ

НЭГТГЭСЭН: ЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

М.ЭНХБАЯР



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын зорилтуудын хэрэгжилт

2025 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Д/д	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Нийслэлийн өмчийн байр, талбайг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1.2, ХАХТ-3.1.1.3	-	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлого, сая.төг	3,136,5	3,068,9 /Жил/	НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын дагуу иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудтай нийслэлийн өмчийн барилга, байгууламжийн гурвалсан гэрээ 131, хоёр талт гэрээ 16, Үдийн цай хөтөлбөрийн 35, нийт 182 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажиллаж байна. 2025 оны түрээсийн жилийн орлогын төлөвлөгөөг 3,068.9 сая төгрөгөөр баталж, түрээсийн орлого төвлөрүүлэх батлагдсан хуваарийн дагуу 895,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн байдлаар 730,1 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөв төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолд заасан түрээсийн төлбөрийн доод хязгаарын 1мкв үнэ 6000-15000 тогтоосон байна. НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан " Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам" дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулаж Нийслэлийн өмчийн байр талбайг иргэн, аж ахуй нэгжид 1мкв талбайг 25000-45000 түрээслүүлэн ажиллаж байна.	90%

ДАРГА  В.ОЮУМАА

ХЯНАСАН: ЗУХ-ИЙН ДАРГА



Т. ОЮУНТУУЛ

НЭГТГЭСЭН: ЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



М.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН “2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” 01 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 01 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

Албан даалгавар			Хариуцан хэрэгжүүлэх нэгж	Явцын мэдээ	Үнэлгээ	
Заалтын дугаар	Нийслэлийн хэрэгжүүлэх арга хэмжээ	Байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ				
1	2	3	4	5	6	
5. Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд:						
1.	5.1	Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа стандартуудыг цэгцлэх, сайжруулах, стандартыг иргэд, олон нийтэд таниулан сурталчлах, стандартын хэрэгжилтэд хяналт тавих механизм бий болгох, арга хэмжээ авах	Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа стандартуудыг цэгцлэх сайжруулах ажилд санал боловсруулан тусгах, стандартыг иргэд, олон нийтэд байгууллагын олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар дамжуулан таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах	Нийт хэлтэс	2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 1/306 дугаар албан бичгээр хотын стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд Хотын стандарт, хяналтын газраас хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөсний дагуу оролцох 2 албан хаагчийн нэрс, “Хотын стандарт батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төслийн саналыг хүргүүлсэн. Хотын стандартыг иргэд, олон нийтэд байгууллагын олон нийтийн сүлжээ, байгууллагын цахим хуудсаар https://www.umch.ub.gov.mn/news/show/hotyn-standart/mn , дамжуулан таниулан сурталчлах ажлыг зохион байгуулсан.	100%
2.	5.5	Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах	Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг эрчимжүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах	ЗТСХ	Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд тухайн ажил, албан тушаал эрхлэх холбогдох шаардлага хангахгүй 10 албан хаагчдад Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 1-т заасны дагуу сонсох ажиллагаа хийхээр мэдэгдэл өгснөөр 7 албан хаагчийг чөлөөлж, 5 албан хаагчийг хуульд заасан хугацаа дуусмагц албан тушаалаас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн.	100%

3.	5.7	Төрийн албыг цомхон, үр дүнтэй ажиллах тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээ авах	Байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн батлан, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлэх	ЗТСХ	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/980 дугаар захирамжаар баталсан Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Өмчийн харилцааны газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарын дагуу газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/80 дугаар тушаалаар бүтцэд өөрчлөлт оруулсан.	100%
4.	5.8	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлэх	Нийслэлийн төсвөөс санхүүждэг 2 үйлдвэрийн газруудыг нэгтгэх, татан буулгах саналыг эрх бүхий байгууллагад танилцуулан, засаглалыг сайжруулах арга хэмжээ авах	ӨМХ	<u>Засаглалыг сайжруулах ажлын хүрээнд:</u> 1. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК НЗД-ын 2024 оны А/311 дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгээс тус компанийн анхны хувьчилсан байдал, түүнтэй холбоотой шүүхийн шийдвэрүүд, улсын бүртгэл дэх хуулийн этгээдийн бүртгэл, төсвийн хөрөнгө оруулалт, бүртгэл хөтлөлт, одоогийн хөрөнгийн байдал, ногдол ашиг хуваарилалт, газар, түүний өнөөгийн байдал зэрэг асуудлуудын хүрээнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. НИТХ-ын 2024 оны 41 дүгээр тогтоолоор “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн хувийн өмчийн хувьцааны хууль ёсны өвлөгчид өвлөх эрхээсээ татгалзах хүсэлт гаргасныг үндэслэн өр төлбөрт суутган тооцох хэлцэл хийж, орон нутгийн өмчид 100 хувь шилжүүлэн авах, улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргад зөвшөөрсний дагуу “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн 51 хувийн өвлөгч Н.Булганбаатартай хэлэлцээр хийж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 01 дүгээр тогтоолоор 100 хувь нийслэлийн өмчид шилжүүлэн, 100 хувийн хувьцаа эзэмшигчээр НИТХ болгон өөрчилсөн. <u>Үйлдвэрийн газар өөрчлөн байгуулах ажлын хүрээнд:</u> 1. Засаглалыг сайжруулах ажлын хүрээнд 4 үйлдвэрийн газрыг хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн, дүрмийг батлуулсан. Үүнд: - НИТХ-ын 2024 оны 36 дугаар тогтоолоор “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк” ХК, - НИТХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолоор “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК, - НИТХ-ын 2024 оны 38 дугаар тогтоолоор “Налайх үйлдвэрлэл, технологийн парк” ХК	100%

					2.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолын дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ОНӨААТҮГ-ыг НИТХ-ын 2024 оны 28 дугаар тогтоолоор өөрчлөн байгуулж, дүрмийг шинэчлэн батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: - <i>Зорчигч тээвэр нэг, Зорчигч тээвэр хоёр, Зорчигч тээвэр гурав, Зорчигч тээвэр дөрөв, Зоригч тээвэр тав ОНӨААТҮГ-ыг шинэчлэн байгуулан, дүрмийг баталж, улсын бүртгэлд бүртгүүлэн, бүтэц орон тоог батлуулан, удирдлагыг томилох, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, хөрөнгийн эх үүсвэрийн хамт авлага, өр төлбөрийг тооцон шилжүүлэх ажлыг зохион байгуулан 2024 оны зорилтот түвшинг баталсан.</i> - <i>“Зорчигч тээврийн нэгтгэл”, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТГ-ыг татан буулган, эрх үүрэг хариуцлага, хөрөнгийг шинээр байгуулсан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 5 ОНӨААТҮГ-т тус тус шилжүүлсэн.</i> <u>Үйлдвэрийн газар татан буулгах ажлын хүрээнд:</u> 1. “Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК-ийг НИТХ-ын 2024 оны 61 дүгээр тогтоолоор 2024.04.30-ны өдрөөр тасалбар болон татан буулган, нийслэлийн Засаг даргын А/1344 дүгээр захирамжаар татан буулгах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Үндсэн чиг үүргийн хүрээнд Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн хэрэгжүүлж байсан төслүүдийг дараах байгууллагуудад шилжүүлсэн. Үүнд: - <i>ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 411 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын хөндлөн чиглэлд метро нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд тус төслийг “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-т</i> - <i>“Шинэ тойрог зам” төслийг Нийслэлийн замын хөгжлийн газарт тус тус шилжүүлэхээр шийдвэрлэсэн.</i> 2.“Нийслэлийн Засаг даргын 2024.05.10-ны өдрийн А/511 дүгээр захирамжаар“Улаанбаатар зүүн азийн наадам зохион байгуулах хороо” ХК-д бүртгэлтэй спортын хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжид тооллого хийх, бүртгэл, элэгдэл хорогдлыг	
--	--	--	--	--	---	--

					тооцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан хөрөнгийг Монголын хүүхдийн ордонд, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газарт хүлээлгэн өгсөн. 3.Бэлчээрийн менежмент хэрэгжүүлэх төслийн нэгж ОНӨТҮГ-ыг НИТХ-ын 2024.06.18-ны өдрийн 87 дугаар тогтоолоор татан буулгасан. СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-д хөрөнгийг холбогдох журмын дагуу хүлээлцэн, хаалтын баланс аудитын дүгнэлт, архивын баримтуудыг хүлээлгэн өгсөн байна. 4."Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ-ыг НИТХ-ын 2024 оны 129 дүгээр тогтоолоор татан буулгахаар шийдвэрлэн Нийслэлийн Засаг даргын 2024.11.04-ний өдрийн А/1298 дугаар захирамжаар татан буулгах ажлын хэсгийг байгуулан тус ОНӨТҮГ-ын баланст бүртгэлтэй нийт 36,573,200.00 төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг “Шинэ зуун мод хөгжлийн корпорац”-д хүлээлгэн өгсөн.	
5.	5.10	Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн давхардал хийдэл зөрчлийг арилгаж уялдаа холбоог сайжруулахад санал өгөх	Нийт хэлтэс	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд оруулах саналыг НЗДТГ-т хүргүүлсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй НИТХТ-ийн 2014 оны 54, 55, 65, 66, 67, 68 дугаар тогтоолоор батлагдсан өмчийн харилцаатай холбоотой 10 журмын давхардал хийдлийг арилгахаар судалгаа хийсэн. Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг” шинэчлэн боловсруулах саналыг НЗДТГ-т 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр цахимаар хүргүүлсэн.	100%
7. Хүний хөгжлийн чиглэлээр:						
6.	7.12	Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд иргэдийн	Байгууллагын нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээнд үе шаттай хамруулах	Нийт хэлтэс	Албан хаагчид өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулахаар судалгаа авахад 2 албан хаагч харьяа дүүргийн эрүүл мэндийн төвд, үлдсэн албан хаагчид хамрагдаж амжаагүй байсан.. Үүний дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт ямар эмнэлгийн байгууллагаар хамрагдах тухай санал авч, Улсын нэгдүгээр эмнэлэг болон Хавдар судлалын эмнэлэгт үзүүлэх саналыг нэгтгэн удирдлагад танилцуулсан. Мөн нийслэлийн Өмчийн	100%

		хамрагдалтыг нэмэгдүүлэх			харилцааны газрын нийт албан хаагч нарт "Амны хөндийн эрүүл мэнд"-ийн талаар сургалт, урьдчилан сэргийлэх үзлэг хийх хүсэлтийг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 59 дугаар албан бичгээр ирүүлсэн. Тус хүсэлтийн дагуу нийт албан хаагчдаас санал авсан ба 20 албан хаагч хамрагдах хүсэлтэй, 22 албан хаагч хамрагдахгүй гэсэн санал өгсөн. Албан хаагчдын саналын дагуу “Дөл дент” шүдний эмнэлэгтэй холбогдож, 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр албан хаагчдыг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтад хамруулахаар болсон. Дөл дент шүдний эмнэлгийн хамт олон 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 14 цагт Нийслэлийн Өмчийн харилцааны газар ирж "Амны хөндийн эрүүл мэнд"-ийн талаар сургалт зохион байгуулж, байгууллагын 15 албан хаагчдыг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	
--	--	-----------------------------	--	--	--	--

---oOo---